



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2017 оны 4 сарын 12 өдөр

Дугаар 80

Улаанбаатар хот

Нэр бүхий хөдөө аж ахуйн биржийн
арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа
эрхлэх тусгай зөвшөөрлийг сэргээх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.1.5, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, Хорооны 2013 оны 69 дүгээр тогтоолоор баталсан “Хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн тусгай зөвшөөрлийн түр журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дах хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Энэхүү тогтоолын хавсралтад дурдсан нэр бүхий 2 хуулийн этгээдийн хөдөө аж ахуйн биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг 2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрөөс сэргээсүгэй.

2. Хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг болон Хорооны 2017 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 36 дугаар тогтоолын 2-т заасныг чанд биелүүлж ажиллахыг үүрэг болгож, цаашид зөрчил давтан гаргасан тохиолдолд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх болохыг “Ивээлт-Инэл” ХХК, “Вүүдсоунд ХААБ” ХХК-ийн удирдлага, эрх бүхий албан тушаалтанд анхааруулсугай.


3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



С.ДАВААСҮРЭН

Санхүүгийн зохицуулах хорооны
2017 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн
80 дугаар тогтоолын хавсралт



Д/Д	ХААБ-ийн нэрс
1	“Ивээлт-Инэл ХААБ” ХХК
2	“Вүүдсоунд ХААБ” ХХК